



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А/11

Хажуу шинэ-Ус

Эцэг эхийн зөвлөл байгуулах тухай

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 03-ний өдрийн 03 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Засаг даргын Тамгын газрын дэргэдэх эцэг эхийн зөвлөлийг 2023 оны 05 дугаар сарын 25-ний өдрөөс эхлэн 2 жилийн хугацаатай дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Зөвлөлийн дарга: Н.Болор-Эрдэнэ (Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Э.Лайжинханд (Архив, бичиг хэргийн эрхлэгч)

Гишүүд: Л.Батбаатар (4 дүгээр багийн Засаг дарга)

Н.Ганбат (Төсвийн ерөнхий нягтлан бодогч)

Д.Сарангэрэл (Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн)

2. Байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэдэх эцэг эхийн зөвлөл байгуулж ажиллуулах зөвлөмжийг үйл ажиллагаандаа чиглэл болгон байгууллагын хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажиллахыг зөвлөлийн бүрэлдэхүүнд даалгасугай.

3. Засаг даргын Тамгын газрын төрийн албан хаагч нарын хүүхдийн дунд зохион байгуулж, хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг хагас бүтэн жилээр хамт олонд тайлагнаж ажиллахыг зөвлөлийн дарга (Н.Болор-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан 2022 оны 04 дүгээр сарын 14-ны өдрийн 09 дүгээр тоот тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА

Н.ӨЛЗИЙТОГТОХ

